



Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль
Оюутны Холбоо

Гадаад Хэлний Сургуулийн
Оюутны Зөвлөлийн 9-р сарын ажлын тайлан

Тайланг дэмжсэн:

Оюутны Холбооны тэргүүн :

/ Ш. Өнөболд /

Тайланг хянасан:

Оюутны Холбооны ерөнхий нарийн бичгийн дарга :

/ Г. Ганчимэг /

Тайланг боловсруулсан:

Оюутны Зөвлөлийн нарийн бичиг:

/ Б. Гуамарал /

Энэ сард зохион байгуулагдсан үйл ажиллагаа:

1. ШУТИС - ийн хичээлийн шинэ жилийн нээлт
2. Оюутны зөвлөлийн намрын элсэлт
3. Шинэ элсэгчдын нэгдсэн уулзалт
4. Лаа болон хоолны өдөрлөг
5. Ариун цэврийн хэрэглэлийн сав
6. Гишүүн чадавхжуулах сургалт

1. ШУТИС - ийн хичээлийн шинэ жилийн нээлт

2022 оны 9 сарын 1 өдөр зохион байгуулагдсан. Тус үйл ажиллагаанд салбар сургуулиудын удирдах албан тушаалтан болон оюутны төлөөлөл оролцсон. Үйл ажиллагааны үеэр ГХС-ийн оюутнууд суралцаж буй хэлнийхээ үндэсний хувцсыг өмсөж, сургуулийн танилцуулга бүхий боршуур тараасан бөгөөд ГХС-ийн асар дээр ном болон суралцаж буй хэлнийхээ үндэсний тоглоом зэргээр танилцуулга хийсэн.



Зураг 1. Нээлтийн үйл ажиллагааны үеэр

2. Оюутны зөвлөлийн намрын элсэлт

Жил бүр зохион байгуулдаг оюутны зөвлөлийн намрын элсэлтийг 2022 оны 8 сарын 31-ээс эхлэн 9 сарын 6 хүртэл 7 хоногийн хугацаатайгаар явуулсан ба уг элсэлтээр 7 оюутныг сонгон шалгаруулж аван, нийт 20 гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.



Зураг 2. ГХС 2022 – 2023

Б. Бадамгарав	Дарга	А. Төртогтох	Идэвхтэн гишүүн
М. Анужин	Дэд дарга	Д. Сүх-Эрдэнэ	Идэвхтэн гишүүн
Б. Гуамарал	Нарийн бичиг		
Р. Дэжидбал	ДҮАХА менежер		
А. Дэчинжамц	ДҮАХА гишүүн		
Ц. Гүндэгмаа	ДҮАХА гишүүн		
Д. Мөнхчулуун	СХА менежер		
М. Түвшингэрэл	СХА гишүүн		
Н. Гантулга	СХА гишүүн		
Б. Баасанбат	СХА гишүүн		
Т. Дөлгөөн	СХА гишүүн		
Д. Билигт-Очир	СХА гишүүн		
Э. Отгонбаяр	ЭШТА менежер		
Б. Оюундарь	ЭШТА гишүүн		
Номиндэлгэрмаа	ЭШТА гишүүн		
Б. Төр-орших	ОНХА менежер		
Г. Мөнхшүр	ОНХА гишүүн		
О. Сансар	ОНХА гишүүн		

3. Шинэ элсэгчдийн нэгдсэн уулзалт

2022 оны 9 сарын 9 өдөр зохион байгуулагдсан. Тус сургалтанд Гадаад Хэлний Сургуулийн захирал Ц. Энхбаатар, чанар сургалтын албаны дарга А. Болормаа, хэрэглээний хэл шинжлэлийн салбарын эрхлэгч Ц. Цэцэгмаа, Оюутны Соёл Үйлчилгээний Албаны мэргэжилтэн Ц. Болдбаатар, номын сангийн мэргэжилтэн Э. Энхтүвшин, сургалтын албаны ажилтан С. Ариунзаяа, ази судлалын тэнхимийн эрхлэгч Ц. Эндэнэзаяа, Оюутны Зөвлөлийн гишүүд, 1 дүгээр курсийн зөвлөх багш нар болон шинэ элсэгчид оролцсон. Гадаад Хэлний Сургуулийн Захирал Ц. Энхбаатар элсэгчдэд сургуулийн үйл ажиллагааг танилцуулсан. Хэрэглээний хэл шинжлэлийн салбарын эрхлэгч Ц. Цэцэгмаа салбарын үйл ажиллагааны тухай танилцуулсан. Оюутны Соёл Үйлчилгээний Албаны мэргэжилтэн Ц. Болдбаатар албаны үйл ажиллагаа болон оюутнуудад чиглэсэн клубүүдийн талаар мэдээлэл өгсөн. Номын сангийн мэргэжилтэн Э. Энхтүвшин номын сангийн үйл ажиллагааны чиглэл, номын сангаар хэрхэн үйлчлүүлэх болон номын сан доторх бүтэц зохион байгуулалтын талаар танилцуулсан. Сургалтын албаны ажилтан С. Ариунзаяа сургалтын албанаас оюутнуудад чиглэн явуулдаг үйл ажиллагаа, үндсэн чиглэлийг танилцуулсан. Ази судлалын тэнхимийн эрхлэгч Ц. Эрдэнэзаяа тэнхимийн үйл ажиллагаа, ерөнхий чиглэлийн тухай танилцуулсан. Солонгос хэлний ахлах багш Т. Мөнхжаргал “Кассен” клубын талаар товч танилцуулга хийсэн. Япон хэлний багш Т. Солонго болон ахлагч Т. Дөлгөөн “Хитонен” клубын талаар танилцуулсан. Оюутны Зөвлөлийн Дарга М. Анужин оюутны зөвлөлийн үйл ажиллагаа, чиглэлийн тухай мэдээлэл хүргэсэн.



Зураг 3. Сургалтын үйл явц

4. Лаа болон хоолны өдөрлөг

Жил бүр оюутны зөвлөлийн хүрээнд зохион байгуулдаг лаа болон хоолны өдөрлөгөө 2022 оны 9 сарын 18 өдөр зохион байгуулсан. Уг өдөрлөг нь гишүүд хоорондоо танилцах болон цаашдын үйл ажиллагаа, зорилгоо хэлэлцэхэд чиглэсэн өдөрлөг юм.



Зураг 4. Өдөрлөгийн үйл явц

5. Ариун цэврийн хэрэглэлийн сав

ГХС-ийн оюутнуудад зориулсан ариун цэврийн хэрэглэлийн савыг I байрны 3 давхар болон II байрны 3 давхарт дахин байршуулав. Уг савны зориулалт нь охидод тулгардаг асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн бөгөөд сар бүр ОЗ-ийн гишүүд савны дүүргэлтийг хариуцан ажилладаг.



Зураг 5. Ариун цэврийн хэрэглэлийн сав

6. Оюутны зөвлөлийн гишүүн чадавхжуулах сургалт

2022 оны 9 сарын 29 өдөр зохион байгуулагдсан. Тус сургалтын зорилго нь гишүүн нэг бүрийг чадавхжуулах, Оюутны Зөвлөлийн үйл ажиллагаа, зорилго, чиглэлийг мэдүүлэх байсан бөгөөд сургалтын явцад гишүүд идэвхтэй оролцон уг сургалт амжилттай болж өндөрлөсөн. Сургалтанд Оюутны Зөвлөлийн 2022 оны шинэ элсэгчид болон бусад гишүүд оролцсон ба 2021 оноос 2022 оны Оюутны Холбооны тэргүүн Б. Эрдэнэбүрэн уригдан, тус сургалтыг удирдан явуулсан.



Зураг 6. Сургалтын үйл явц

Б. Бадамгарав	Дарга
М. Анужин	Дэд дарга
Б. Гуамарал	Нарийн бичиг
Р. Дэжидбал	ДҮАХА менежер
А. Дэчинжамц	ДҮАХА гишүүн
Ц. Гүндэгмаа	ДҮАХА гишүүн
Д. Мөнхчулуун	СХА менежер
М. Түвшингэрэл	СХА гишүүн
Т. Дөлгөөн	СХА гишүүн
Б. Баасансат	СХА гишүүн
Д. Билигт-Очир	СХА гишүүн
Б. Оюундарь	ЭШТА гишүүн
Номиндэлгэрмаа	ЭШТА гишүүн

Батлав:

ГХС-ийн чанар сургалтын албаны дарга:/А. Болормаа/

Гадаад Хэлний Сургуулийн Оюутны зөвлөлийн ажлын үзүүлэлт

2022 оны 9-р сар

№	Үзүүлэлтүүд	Сард авбал Зохих хувь	Нийт	Тайлбар
1	Зохион байгуулсан ажлын үр дүн	50%		
2	ШУТИС-ийн нэгдсэн зохион байгуулалттай ажлын үр дүн	20%		
3	Өгсөн үүрэг даалгаврын биелэлт	20%		
4	Хурлын ирц, хурлын дэг, удирдах зөвлөлийн гишүүний ёс зүйн үүрэг хариуцлага	10%		
5	Нийт	100%		
6	Олгох хувь			

Тайланг дэмжсэн:

Оюутны Холбооны тэргүүн:

/ Ш.Өнөболд /

Тайланг хянасан:

Оюутны Холбооны ерөнхий нарийн бичгийн дарга:

/ Г. Ганчимэг /

Тайланг боловсруулсан:

Оюутны Зөвлөлийн нарийн бичиг:

/ Б. Гуамарал /